

**“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2026 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

2026 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Биелэлт	Хувь
1	2	3	4	5	6	7
Нэг. Зохион байгуулалтын үйл ажиллагааны талаар						
1	Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн	1.1.“Ёс зүйн дэд хороо”-ны 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авч нэгтгэн, Газрын даргаар батлуулах	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Газрын “Ёс зүйн дэд хороо”-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
2	2.2.1.байгууллага ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төрлийг тодорхойлж, төсвийн хамт төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулна	1.2.“Ёс зүйн дэд хороо”-ны төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэж, Газрын даргад танилцуулах	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/09 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг хагас жилийн байдлаар нэгтгэн, Ёс зүйн дэд хорооны даргад танилцуулан баталгаажуулав. Төлөвлөгөөний хэрэгжилт 79,4 хувьтай.	100
3	3.2.3.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ.	1.3.Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээ, тайланг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2026 оны “Журам батлах тухай” А/555 дугаар захирамжийн дагуу Газрын Ёс зүйн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, мэдээг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.	100
4		1.4.Ёс зүйн дэд хорооны хурлын тэмдэглэлийг тухай	Арга хэмжээний	100 хувь	Тайлант хугацаанд Газрын Ёс зүйн дэд хороо нийт 2 удаа хуралдаж, хуралдааны	100

	Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалт	бүр цаасан суурьтай албажуулах	хэрэгжилтийн хувь		тэмдэглэлийг тухай бүр цаасан суурьтай албажуулсан.	
5		1.5.“Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааны талаарх холбогдох материалын бүрдлийг ханган Газрын Архивд хүлээлгэн өгнө.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Архивын 2025 оны хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу <i>Ёс зүйн дэд хорооны холбогдох баримт бичгийг</i> цахим болон цаасан хэлбэрээр архивын нэгж үүсгэн Газрын Архивт хүлээлгэн өгсөн.	100
Хоёр. Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан шийдвэрлэх хүрээнд						
6	Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 3.3.1.байгууллага нь иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авч, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшинэ. 3.3.3.байгууллага ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж, хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.	2.1.Ажилтан, албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг цаасан болон цахим хэлбэр (QR код)-ээр хүлээн авч бүртгэх	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Төлөвлөгөөний дагуу ёс зүйн зөрчил, гомдол, мэдээллийг хүлээж авах QR код бүхий зурагт холбоос, саналын “Хайрцаг”-ийг Газрын мэдээллийн самбарт байршуулан ажилтан, албан хаагч болон иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй байна.	100
7	Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 3.3.1.байгууллага нь иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авч, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшинэ. 3.3.3.байгууллага ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж, хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.	2.2.Ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийн үндэслэлийг шалган тогтоож, хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд дүгнэлт гаргаж, дүгнэлтийг холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэх	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээлэл ирээгүй болно.	100
8	4.3.4.байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг биелүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг жил бүр олон нийтэд мэдээлнэ.	2.3.Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, тайлан, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэсэн шийдвэрийг газрын вэб хуудаст байршуулан олон нийтэд мэдээлнэ.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Газрын Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө, холбогдох дүрэм, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг газрын вэб хуудас, мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажилласан.	100

9	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 1.1.3.албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас нэвтрүүлж, хэрэглэж хэвшүүлнэ.	2.4. Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудсыг Ёс зүйн дэд хорооны дүгнэлт, томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр албажсанаас хойш ажлын 5 хоногийн дотор хөтөлнө	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээлэл ирээгүй болно.	100
Гурав. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн хэрэгжилтийг ханган ажиллах						
10	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 3.1.5.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан журам, бусад хуульд заасан эрх хэмжээний хүрээнд батлан мөрдүүлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг Ёс зүйн хорооноос санал авч шинэчлэн баталж, мөрдүүлэх арга хэмжээг авна.	3.1.Газрын даргын 2023 оны А/69 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлуулах	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Газрын даргын 2023 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг холбогдох хууль тогтоомжид үндэслэн шинэчлэн боловсруулж, нийт ажилтнуудаас санал авч, Ёс зүйн дэд хорооны 01, 02 дугаар хуралдаанаар дүрмийн төслийг хэлэлцүүлэн нийт гишүүдээс санал авч, хурлын тэмдэглэлээр баталгаажуулан, Газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлуулж, дүрмийг газрын дотоод сүлжээнд НХОГ группд, QR болон постер байдлаар бэлтгэн байршуулж, нийт ажилтан, албан хаагч нарт мэдээлэл хүргэж, танилцуулав.	100
11	Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 1.1.1.байгууллага албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх	3.2.Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудсаар нийт албан	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны “Аргачлал батлах тухай” 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас” -ын А, Б хэсгийг тус тусад нь линк үүсгэж, үнэлгээний хуудсыг бөглөх зааварчилгааг, мэдээллийг постер	100

	эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. 1.1.2.ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагч ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлнэ.	хаагчдад ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж, ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагчаас ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргуулж ажиллах			байдлаар бэлтгэн албан хаагч нарт танилцуулан, үнэлгээг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд авч, үр дүнг нэгтгэсэн. Үнэлгээнд нийт 96 ажилтан хамрагдахаас 76 ажилтан хамрагдсан. Албан хаагч өөрийн чиг үүргийн хүрээнд ажиллахад тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг тодорхойлох үнэлгээ, Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээлийг тодорхойлох үнэлгээнд үнэлгээнд хамрагдсан 76 албан хаагч 100 хувь эрсдэлийн түвшин бага буюу 1-5 оноотой үнэлэгдсэн тул шууд арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагагүй бөгөөд хяналтыг үргэлжлүүлэн, холбогдох хууль тогтоомж, төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй гэж дүгнэн, үнэлгээний нэгтгэл, зөвлөмжийг Ёс зүйн дэд хорооны даргад танилцуулан, мэдээллийг постер хэлбэрээр бэлтгэн Газрын дотоод сүлжээнд “НХОГ” группд байршуулж нийт ажилтнуудад танилцуулсан.	
12	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 2.1.3.байгууллага төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулж хэвшүүлнэ.	3.3.Шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад Газрын “Ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Тайлант онд шинээр томилогдсон 4 ажилтанд Газрын “Ёс зүйн дүрэм”-ийг танилцуулсан. Гуравдугаар улиралд сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	50


13	“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 2.1.1.байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулна.	3.4.Газрын нийт албан хаагчдад Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулах (Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх, ёс зүй, харилцаа хандлагыг сайжуулах чиглэлээр)	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Төлөвлөгөөний дагуу 3, 4 дүгээр улиралд Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахаар ажиллаж байна.	-
14	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 2.1.4.ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна.	3.5.Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Тайлант хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.	100
15	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” (2024-2030)-ийн 2.2.4.төрийн албан хаагч бүрийг ёс зүйтэй, шударга ажиллах үүргээ сайтар ухамсарлан ойлгож, чанд мөрдөхөд чиглүүлэн ёс зүйн асуудал хариуцсан албан тушаалтантай харилцах, холбогдох зөвлөгөөг авах талаарх мэдээллийг хүн бүрд хүргэх ажлыг байгууллага хэрэгжүүлнэ.	3.6.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох дүрэм, журмын талаар танилцуулга, мэдээлэл бэлтгэж Газрын дотоод сүлжээ, мэдээллийн самбарт 10-аас доошгүй удаа байршуулж, сурталчлан мэдээллэж, холбогдох зөвлөгөөг өгч ажиллах	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Төрийн албан хаагчийн ёс зүйн урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох дүрэм, журмын талаар танилцуулга, мэдээлэл постер хэлбэрээр бэлтгэж Газрын дотоод сүлжээнд “НХОГ” группд нийт 5 удаа байршуулсан.	100

16	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн 3.2.2.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, дүрмийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээлэх зэрэг чиглэлээр нөлөөллийн аяныг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулан үр дүнг тооцно.	3.7.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээлэх чиглэлээр зохион байгуулагдаж байгаа аянд нэгдэж, 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулах	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Төлөвлөгөөний дагуу 3, 4 дүгээр улиралд Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахаар ажиллаж байна.	-
17	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн 3.1.7.ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын гишүүдийг мэргэшүүлнэ.	3.8.Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтад Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнээс 1-2 хүнийг хамруулна.	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь	Төлөвлөгөөний дагуу 3, 4 дүгээр улиралд Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлийн сургалтад Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хамруулахаар ажиллаж байна.	-
Дундаж хэрэгжилт						79,4

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ТОГТООЛ,
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Б.ГАНЗОРИГ

Ц.ГҮРБАДАМ

Г.ИЖИЛМАА